



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2026/012/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Говьсүмбэр аймаг 2026 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543179, Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn Гэрээт аудитор: Д.Оюунбат Цахим хаяг: Oyunbatdorjkhhand@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govिसumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТӨСВИЙН ШУУД
ЗАХИРАГЧ Ж.ОЮУНБИЛЭГ ТАНАА

2026.02.23 № 16
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

4226050037

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 72 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээгээр 89.0 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 - 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ГСА	Говьсүмбэр аймаг
НА	Нотлох аудит
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4	0.00	0.00
33	АВЛАГА	5	0.00	363,319.92
335	Бусад авлага		0.00	363,319.92
33510	Байгууллагаас авах авлага		0.00	363,319.92
35	БАРАА МАТЕРИАЛ	6	3,408,298.00	4,458,798.00
354	Хангамжийн материал		3,408,298.00	4,458,798.00
35410	Бичиг хэргийн материал		0.00	650,000.00
35420	Аж ахуйн материал		0.00	95,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл		753,000.00	753,000.00
35470	Бусад хангамжийн материал		2,655,298.00	2,960,798.00
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		<u>3,408,298.00</u>	<u>4,822,117.92</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	521,368,600.82	560,432,044.20
39100	Газар			
392	Биет хөрөнгө		470,538,600.82	509,602,044.20
39201	Барилга, байгууламж, орон сууц		325,183,376.00	325,183,376.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		-16,664,407.11	-22,082,304.63
39203	Авто-тээврийн хэрэгсэл		60,000,000.00	154,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		-6,666,666.68	-31,933,333.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		104,451,038.00	115,101,038.00
39206	Хуримтлагдсан элэгдэл		-33,236,737.07	-63,181,316.65
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		43,522,727.44	43,522,727.44
39208	Хуримтлагдсан элэгдэл		-6,050,729.76	-11,808,142.56
393	Биет бус хөрөнгө		50,830,000.00	50,830,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө		50,830,000.00	50,830,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл			
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		<u>521,368,600.82</u>	<u>560,432,044.20</u>
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		<u>524,776,898.82</u>	<u>565,254,162.12</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9	28,262.10	4,898,600.00
413	Өглөг		28,262.10	4,898,600.00
4136	Бусад өглөг		28,262.10	4,898,600.00
41361	Байгууллагад төлөх өглөг		28,262.10	4,898,600.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		<u>28,262.10</u>	<u>4,898,600.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо		524,748,636.72	560,355,562.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		120,685,525.69	120,685,525.69
51101	Өмч: - төрийн		50,830,000.00	50,830,000.00
51102	- хувийн		69,855,525.69	69,855,525.69

512	Хуримтлагдсан үр дүн		401,116,586.63	436,723,512.03
51210	Өмнөх үеийн үр дүн		286,990,546.58	401,116,586.63
51220	Тайланг үеийн үр дүн		114,126,040.05	35,606,925.40
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс			
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		2,946,524.40	2,946,524.40
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга			
51600	Нөөцийн сан			
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		<u>524,748,636.72</u>	<u>560,355,562.12</u>
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		<u>524,776,898.82</u>	<u>565,254,162.12</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,208,441,321.00	1,421,810,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	141,141,321.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	141,141,321.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,067,300,000.00	1,421,810,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,067,300,000.00	1,421,810,000.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	108,290,916.44	140,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	108,290,916.44	140,000.00
120009	Бусад орлого	0.00	140,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	108,090,916.44	0.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	200,000.00	0.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,316,732,237.44	1,421,950,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,202,294,008.58	1,386,343,074.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	941,079,085.94	1,215,830,686.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	353,482,279.53	591,737,801.18
210101	Үндсэн цалин	199,655,758.59	259,163,370.88
210102	Нэмэгдэл	117,133,960.94	251,321,149.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,495,000.00	45,527,600.00
210104	Урамшуулал	26,197,560.00	35,725,680.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,199,909.47	73,967,225.06
210201	Тэтгэврийн даатгал	30,074,855.86	50,269,450.92
210202	Тэтгэмжийн даатгал	3,534,822.80	5,917,378.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,995,998.98	2,986,951.11
210204	Ажилгүйдлийн даатгал	1,767,411.39	2,958,689.01
210205	Эрүүл мэндийн даатгал	6,826,820.44	11,834,756.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,073,242.42	29,436,620.00
210401	Бичиг хэрэг	5,202,000.00	3,239,800.00
210402	Тээвэр, шатахуун	21,000,000.00	23,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,138,742.42	1,825,120.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,732,500.00	1,371,700.00
2105	Нормативт зардал	246,740.00	5,980,246.00
210502	Хоол, хүнс	246,740.00	5,980,246.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,958,500.00	6,230,450.00
210604	Урсгал засвар	14,958,500.00	6,230,450.00
2107	Томилолт, зочны зардал	24,858,000.00	14,910,000.00
210702	Дотоод албан томилолт	19,858,000.00	14,910,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,000,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	368,958,465.54	385,193,231.42
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	365,980,710.54	381,372,076.42

210803	Даатгалын үйлчилгээ	2,296,400.00	2,300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	118,525.00	118,525.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	490,000.00	1,329,800.00
210807	Газрын төлбөр	50,830.00	50,830.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,301,948.98	108,375,112.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,516,314.50	34,188,555.86
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,785,900.00	7,800,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	34,999,734.48	66,386,556.62
210904	Найдваргүй авлагын алдагдал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	261,214,922.64	170,512,388.46
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	24,715,500.00	11,263,700.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	24,715,500.00	11,263,700.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	156,811,146.50	13,700,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	128,669,825.50	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21,141,321.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,000,000.00	13,700,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	79,688,276.14	145,548,688.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	79,688,276.14	145,548,688.46
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,202,294,008.58	1,386,343,074.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	114,438,228.86	35,606,925.40
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	312,188.81	0.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	312,188.81	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-312,188.81	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	114,126,040.05	35,606,925.40

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,208,441,321.00</u>	<u>1,421,950,000.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	140,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	140,000.00
120009	Бусад орлого	-	140,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,208,441,321.00	1,421,810,000.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	141,141,321.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	141,141,321.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,067,300,000.00	1,421,810,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,067,300,000.00	1,421,810,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,166,849,012.00</u>	<u>1,316,500,000.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,166,849,012.00	1,316,500,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	905,387,349.86	1,145,772,772.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	353,482,279.53	591,737,800.18
210101	Үндсэн цалин	199,756,508.59	259,879,151.31
210102	Нэмэгдэл	117,133,960.94	250,805,367.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,495,000.00	45,327,600.00
210104	Урамшуулал	26,096,810.00	35,725,680.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,171,647.87	73,995,487.16
210201	Тэтгэврийн даатгал	30,045,993.76	50,297,713.02
210202	Тэтгэмжийн даатгал	3,534,822.80	5,917,378.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,996,599.48	2,986,951.11
210204	Ажилгүйдлийн даатгал	1,767,411.39	2,958,689.01
210205	Эрүүл мэндийн даатгал	6,826,820.44	11,834,756.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,177,742.42	32,271,377.00
210401	Бичиг хэрэг	5,000,000.00	4,290,300.00
210402	Тээвэр, шатахуун	21,000,000.00	23,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,138,742.42	1,825,120.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,039,000.00	3,155,957.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,958,500.00	7,888,000.00
210604	Урсгал засвар	14,958,500.00	7,888,000.00
2107	Томилолт, зочны зардал	24,858,000.00	14,910,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	19,858,000.00	14,910,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	368,958,465.54	384,156,552.34
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	365,980,710.54	380,335,397.34

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	2,296,400.00	2,300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	118,525.00	118,525.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	490,000.00	1,329,800.00
210807	Газрын төлбөр	50,830.00	50,830.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,780,714.50	40,813,555.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,994,814.50	33,013,555.86
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,785,900.00	7,800,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	261,461,662.14	170,727,227.46
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	24,962,240.00	11,478,539.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	24,962,240.00	11,478,539.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	156,811,146.00	13,700,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	128,669,825.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21,141,321.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,000,000.00	13,700,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	79,688,276.14	145,548,688.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	79,688,276.14	145,548,688.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>41,592,309.00</u>	<u>105,450,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	41,592,309.00	105,450,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	41,592,309.00	105,450,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	41,592,309.00	105,450,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	41,592,309.00	105,450,000.00
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(41,592,309.00)</u>	<u>(105,450,000.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	120,685,525.69	16,251,369.12	273,685,701.86	0.00	410,622,596.67
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	13,304,844.72	0.00	13,304,844.72
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	120,685,525.69	16,251,369.12	286,990,546.58	0.00	423,927,441.39
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-13,304,844.72	0.00	0.00	-13,304,844.72
C09	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	114,126,040.05	0.00	114,126,040.05
C10	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	120,685,525.69	2,946,524.40	401,116,586.63	0.00	524,748,636.72
C11	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	120,685,525.69	2,946,524.40	401,116,586.63	0.00	524,748,636.72
C12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	120,685,525.69	2,946,524.40	401,116,586.63	0.00	524,748,636.72
C19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	35,606,925.40	0.00	35,606,925.40
C20	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	120,685,525.69	2,946,524.40	436,723,512.03	0.00	560,355,562.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
12200	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,412,310,000.00	1,276,401,311.54
122005	Төсвөөс санхүүжих	1,412,310,000.00	1,276,401,311.54
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,412,310,000.00	1,276,401,311.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,412,310,000.00	1,276,401,311.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,342,310,000.00	1,251,222,772.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	612,565,000.00	591,737,800.18
210101	Үндсэн цалин	242,882,900.00	259,879,151.31

210102	Нэмэгдэл	293,156,200.00	250,805,367.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,540,000.00	45,327,600.00
210104	Урамшуулал	32,985,900.00	35,725,680.90
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,060,000.00	73,995,487.16
210201	Тэтгэврийн даатгал	53,081,100.00	50,297,713.02
210202	Тэтгэмжийн даатгал	6,244,700.00	5,917,378.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,995,800.00	2,986,951.11
210204	Ажилгүйдлийн даатгал	1,248,900.00	2,958,689.01
210205	Эрүүл мэндийн даатгал	12,489,500.00	11,834,756.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,500,000.00	32,271,377.00
210401	Бичиг хэрэг	7,500,000.00	4,290,300.00
210402	Тээвэр, шатахуун	25,000,000.00	23,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,000,000.00	1,825,120.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	3,155,957.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,500,000.00	7,888,000.00
210604	Урсгал засвар	10,500,000.00	7,888,000.00
2107	Томилолт, зочны зардал	15,000,000.00	14,910,000.00
210702	Дотоод албан томилолт	15,000,000.00	14,910,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	518,685,000.00	489,606,552.34
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	514,555,000.00	485,785,397.34
210803	Даатгалын үйлчилгээ	2,300,000.00	2,300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо	300,000.00	118,525.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	1,329,800.00
210807	Нийтлэг үйлчилгээний төлбөр, хураамж	90,000.00	50,830.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,000,000.00	40,813,555.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,000,000.00	33,013,555.86
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,000,000.00	7,800,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,000,000.00	25,178,539.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	40,500,000.00	11,478,539.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	40,500,000.00	11,478,539.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,500,000.00	13,700,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,500,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,000,000.00	13,700,000.00
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,412,310,000.00	1,276,401,311.54

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13,000.0 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлж, завсрын аудитаар залруулсан.

Залруулсан алдаа:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн (ГХУСАЗСЗ) зардлаас 11,000.0 мянган төгрөгөөр 220 ширхэг "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй" ном, мөн 2,000.0 мянган төгрөгөөр 40 ширхэг "Профессорын эрдмийн дээжис" номыг тус тус худалдан авсан боловч холбогдох газруудад бүртгэж, тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт", 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" 14 дүгээр зүйлийн 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.4, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

Аудитаар нийт 11,302.7 мянган төгрөгийн зөрчил² илрүүлж, 8,912.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 1,930.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгч, 460.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт бичив.

Нийт илрүүлсэн 11,302.7 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Томилолтоор ажилласан албан хаагчдад 460.0 мянган төгрөгийн хоолны унааны олговрыг цалинтай давхардуулж олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-т "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Завсрын аудитаар зөвлөмж өгсөн боловч тооцоо хийж суутгаагүй тул орон нутгийн орлогод төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1 Тайлант онд шатахууны тайланд хавсаргасан 1,930.0 мянган төгрөгийн жолоочийн тооцооны хуудас нь следометрийн заалтгүй, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй хувийн машинд шатахуун зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-т³ заасныг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу, нягтлан бодогч бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүй, тооцоо бодож хүлээн аваагүй, завсрын аудитаар зөрчлийг арилгаагүй тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

1. Зардалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт ГХУСАЗСЗ-ийн зардлаас "Байгалиа хамгаалъя" нэгдсэн арга хэмжээнд 4,112.5 мянган төгрөг, аймгийн баяр наадмын үеэр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4,800.0 мянган төгрөгийн танилцуулга, тараах материал бэлтгэхэд нийт 8,912.5 мянган төгрөг зарцуулсан боловч, уг санхүүгийн баримтад ямар төрлийн тараах материал бэлтгэж, түүнийг хэрхэн иргэдэд түгээсэн талаарх анхан шатны нотлох баримт хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх", 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө.", 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах;" 26 дугаар зүйлийн 26.1 дэх "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө." гэж заасныг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэл дутуу, нягтлан бодогч бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүй тул анхан шатны баримтын бүрдлийг хангаж, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөх

Дээрх акт, албан шаардлагыг хугацаанд нь хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу шийдвэрийн хэрэгжилтийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд буюу тайланг гардаж авснаас 30 хоногийн дотор тус тус Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дүн	3	11,302.7	1	460.0	1	1,930.2	1	8,912.5		
-----	---	----------	---	-------	---	---------	---	---------	--	--

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж		/мянган төгрөгөөр/
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 135,990.3 мянган төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй	1	135,990.3			1	135,990.3			
Дүн									
Нийт дүн	1	135,990.3			1	135,990.3			